



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ  
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

ТУЗ-ын гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, 96.5 дахь хэсэг, Техник импорт ХК-ийн “Дүрэм”-ийн 7.47.11 дэх заалт, Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн хурлын 03 тоот тогтоол, 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн

Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. 2025 оны компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА



Д. ГАНЦЭЦЭГ



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ  
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай  
ТУЗ-ын шийдвэрийг батлах тухай

МУ-ын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2 дахь хэсэг, Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 02-р сарын 13-ны өдрийн 01 тоот тогтоол, 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. Техник импорт ХК-ийн ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ын шийдвэрийг баталсугай.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийн дагуу Техник импорт ХК-ийн 2025 оны Хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцаанд 1000 төгрөг /Нэг мянга/-ийн ногдол ашиг олгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж компанийн хувьцаа эзэмшигчдэд зохих журмын дагуу ногдол ашиг олгох, ногдол ашгийн тайланг Хороо болон Хөрөнгийн биржид хүргүүлж тайлагнахыг компанийн Гүйцэтгэх захирал Д.Ганцэцэг, Бизнес хөгжил, санхүү хариуцсан захирал С.Дашдулам нарт үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА



Д.ГАНЦЭЦЭГ



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ  
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Жилийн үйл ажиллагааны  
тайлан батлах тухай

Компанийн тухай хуулийн 96.4 дэхь хэсэг, Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 03 тоот тогтоол, Техник импорт ХК-ийн 2026 оны 04-р сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. 2025 оны компанийн жилийн үйл ажиллагааны тайланг баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА



Д.ГАНЦЭЦЭГ



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ  
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Үйл ажиллагааны төлөвлөгөө  
батлах тухай

Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 03 тоот тогтоол, 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. 2026 оны компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөг Хавсралт1-ын дагуу баталсугай.
2. Төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА



Д.ГАНЦЭЦЭГ



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ  
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

ТУЗ-ын үйл ажиллагааны тайлан батлах тухай

Техник импорт ХК-ийн “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-ын 12.2 дахь хэсэг, Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03-р сарын 09-ний өдрийн 03 тоот тогтоол, 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Техник импорт ХК-ийн 2025 оны ТУЗ-ын үйл ажиллагааны тайланг баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА



Д.ГАНЦЭЦЭГ



**ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ  
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн  
гишүүдийг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дах заалт, Техник импорт ХК-ийн “Дүрэм”-ийн 7.11.7 дахь заалт, Техник импорт ХК-ийн ТУЗ-ын дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны 2026 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 03 тоот тогтоол, 2026 оны 04-р сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. Дараахь нэр бүхий хүмүүсийг 2026 оны Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдээр сонгосугай.

**ТУЗ-ын ердийн гишүүд:**

1. Т.Тунгалаг
2. Д.Баяраа
3. С.Бүжинлхам
4. Г.Уран-Өлзий
5. Л.Уртнасан
6. Э.Батболд

**ТУЗ-ын хараат бус гишүүд:**

1. Ж.Баярсайхан
2. Б.Батсайхан
3. Б.Нарантуяа

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг 1 жилийн хугацаатай сонгосугай.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь үйл ажиллагаандаа компанийн эрх ашгийг дээдэлж, компанийн үйл ажиллагааг үр дүнтэй удирдан зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Т.Тунгалаг/-д үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА



Д.ГАНЦЭЦЭГ



**ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ  
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

ТУЗ-ын дэргэдэх хороодыг  
байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дах заалт, Техник импорт ХК-ийн “Дүрэм”-ийн 7.62 дах заалт, “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 2.3, 2.4, 2.5, 8 дугаар зүйл, 2026 оны 04-р сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. ТУЗ-ын дэргэдэх Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин, урамшууллын хороог тус тус байгуулсугай.
2. Хороо тус бүрийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

|                                            |              |
|--------------------------------------------|--------------|
| <b>А. Аудитын хорооны дарга</b>            | Ж.Баярсайхан |
| Гишүүд                                     | Б.Батсайхан  |
|                                            | Д.Баяраа     |
| <b>Б. Нэр дэвшүүлэх хорооны дарга</b>      | Б. Нарантуяа |
| Гишүүд                                     | Б.Батсайхан  |
|                                            | Г.Уран-Өлзий |
| <b>В. Цалин, урамшууллын хорооны дарга</b> | Б.Батсайхан  |
| Гишүүд                                     | Ж.Баярсайхан |
|                                            | Т.Тунгалаг   |

1. Техник импорт ХК-ийн Дүрэм, “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-д заасан эрх, үүргийн хүрээнд холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хороодын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА



Д.ГАНЦЭЦЭГ



ТЕХНИК ИМПОРТ ХУВЬЦААТ  
КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

2026 оны ТУЗ-ын төсөв батлах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.13 дахь заалт, Техник импорт ХК-ийн дүрмийн 7.11.13 дахь заалт, “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-ын 12.2, 12.4 дэхь хэсэг, Техник импорт ХК-ийн 2026 оны 04-р сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн Техник импорт ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ** нь:

1. Техник импорт ХК-ийн 2026 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн төсвийг Хавсралт1-т заасны дагуу баталсугай.
2. Тогтоолын дагуу батлагдсан ТУЗ-ын төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, төсвийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ын дарга /Т.Тунгалаг/-д үүрэг болгосугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДАРГА

Д.ГАНЦЭЦЭГ

